

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАНД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 28-ний өдөр

Дугаар.....

БА-094/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 8 давхар, 1 блок, 24.0м*15.0м, 160 (нэг зуун жаран) орны хүчин чадалтай ахмад настан хүүхдийн эмнэлгийн зориулалттай барилга байгууламжид Засгийн Газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 0007337, 008185, 0010948, зөвшөөрлийн дугаар: 181/2020, 048/2021, 027/2022;


2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ШХ-10/2020;

2.3. Захиалагч: Эрүүл Мэндийн Яам оноосон нэр, 9070006111 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9087443 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 1 дүгээр хороо, олимп, Засгийн газрын 8-р байр, 233695, 320916 холбоо барих утас, letter@moh.gov.mn цахим шуудангийн хаяг;

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ оноосон нэр, 9069001077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9116621 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, өөрийн байр, 11323158 холбоо барих утас, info@barilga.gov.mn цахим шуудангийн хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Хаппи Бьюлдинг ХХК оноосон нэр, 9011278089 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5462282 регистрийн дугаар, БУ12-664/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул, 18 дугаар хороо, Эл Эс плаза 304 тоот, 88116102, 88052166 холбоо барих утас, happybuilding75@gmail.com цахим шуудангийн хаяг;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Талст Хайрхан ХХК оноосон нэр, 9011102013 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2821125 регистрийн дугаар, БУ16-1137/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 220-н мянгат, 61-38, 88114964 холбоо барих утас, tawantalst@yahoo.com цахим шуудангийн хаяг;



2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Шувууны Хайрга ХХК оноосон нэр, 9011087048 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5120349 регистрийн дугаар, ЗТ11-244/23 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар;

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, Жалханз хутагт, Дамдинбазарын гудамж 47А-71 тоот, 99100722 холбоо барих утас, bzzih21@gmail.com цахим шуудангийн хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Баянзүрх дүүргийн, Эрүүл Мэндийн Төв оноосон нэр, 9070006004 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9098763 регистрийн дугаар, ЭУ-02/22/2651 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар;

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө, 5 дугаар хороо, 13370, 70150065 холбоо барих утас, bzdemt@gmail.com цахим шуудангийн хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 8 давхар, 1 блок, 24.0м*15.0м, 160 (нэг зуун жаран) орны хүчин чадалтай ахмад настан, хүүхдийн эмнэлгийн зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 8 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 34 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 8 давхар, 1 блок, 24.0м*15.0м, 160 (нэг зуун жаран) орны хүчин чадалтай ахмад настан, хүүхдийн эмнэлгийн зориулалттай барилга байгууламжид ашиглалтанд оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Эрүүл Мэндийн Яамны захиалгатай,
160 ортой ахмад настан, хүүхдийн эмнэлэг

Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)




Нарийн бичгийн дарга:

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын
Барилга байгууламжийн захиалагчийн
хяналтын хэлтсийн Хяналтын инженер

(Г.Батбаяр)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 8 ДУГААР ХОРОО, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ, 8 ДАВХАР, 1 БЛОК, 160 (НЭГ ЗУУН ЖАРАН) ОРТОЙ
АХМАД НАСТАН, ХҮҮХДИЙН ЭМНЭЛГИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 8, дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 8 давхар, 1 блок, 24.0м*15.0м, 160 (нэг зуун жаран) ор бүхий хүчин чадалтай ахмад настан, хүүхдийн эмнэлгийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 7 дугаар давхарт 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 13:00 цагт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.

Хуралд:

- | | | |
|----|--|----------------------------|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2 | Нийслэлийн Хяналт, шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Г.Батбаатар |
| 3 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 4 | Баянзүрх Дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн дарга | И.Батзаяа |
| 5 | Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК, техник хяналтын инженер | Б.Цэрэннадмид |
| 6 | Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Н.Болор-Эрдэнэ |
| 7 | Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Г.Үүрийнгэгээ |
| 8 | Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Зүүн Түгээх Төвийн ахлах инженер | Б.Оргил |
| 9 | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа | Ч.Артаг |
| 10 | Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Б.Оюунжаргал |
| 11 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Б.Ганбаатар
В.Ганбаатар |
| 12 | Зураг төслийн Шувууны Хайрга ХХК-ийн захирал | |
| 13 | Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | Г.Уртнасан |
| 14 | Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын инженер | Г.Батбаяр |
| 15 | Хаппи Бьюдинг ХХК-ийн захирал | Б.Отгонбаатар |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 8 давхар, 1 блок, 24.0м*15.0м, 160 (нэг зуун жаран) ор бүхий хүчин чадалтай ахмад настан, хүүхдийн эмнэлгийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав. Нийслэлийн Хяналт, шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Г.Батбаатар:

- Зураг төсөл зохиогчийн тусгай зөвшөөрөл үзүүлэх;
- Гадна тохижилт, ногоон байгууламжийг зураг төслийн загуу хийж дуусгах, уснаас хамгаалах;
- Зоорийн давхарт орох пандуст саравч хийх;
- Нэг давхрын рентгений өрөөний тусгаарлалтын асуудлыг яаж шийдсэн тайлбар ирүүлэх;
- Лифтийг магадлалд оруулсан дүгнэлт үзүүлэх;
- Техникийн давхрын борооны ус зайлуулах хоолойг доош нь буулгах;
- ХБИ-нд зориулсан 00-д тоноглол хийх;
- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ үзүүлэх;
- Зоорийн давхрын шаланд өнгөлгөө хийх;
- Барилгад хэрэглэсэн материалын тохирлын гэрчилгээ, сертификатыг монгол хэлээр үзүүлэх /цонх, хаалга, эрдэст хөвөн, хөөсөнцөр, ус тусгаарлах пенетрон/.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- Гадна шугам угсралтын ил далд ажлын актын шалгуулах;
- Холигч насосны узелийг хаягжуулах;
- Халаах хэрэгслүүд дээр термостат винтель суурилуулах;
- Техникийн өрөөний АС-ийн шугам хоолойг хаягжуулах;
- АС-ийн шугам угсралтын ил далд ажлын актыг шалгуулах;
- Гадна дулааны шугам мэдээллийн санд бүртгүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Баянзүрх Дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн дарга И.Батзаяа:

- Рентген өрөөний эмчийн өрөөний удирдлагын цонх гаргах, хаалганы урсгал өөрчлөх, хаалт солих, агааржуулалт гаргах;
 - Давхар болгонд сүлжээний холболтыг шалгах, дутууг гүйцээх;
 - 8 давхрын коридорт 3 цонх хагарсан. Өрөөнүүдийн хаалганы хүрээ болон ариун цэврийн өрөөний бүх өрөөний суултуур болон болон алчуур хатаагчийн тогтоогч дутуу байгааг хийж гүйцээх, будах
 - Гадна хаалганы дэргэдэх усны хаялгыг өөрчлөх, уртасгах;
 - Цонхны жийрэг сийгэж байна. Өрөөний өнгө будгийг сэргээх;
 - Агааржуулалтын хоолойд шүүлтүүр байхгүй, решотик хийх;
 - 7-р давхрын өрөөний булангийн цонхны шавар хуурсныг засах;
 - Агааржуулалтын хоолойг будах;
 - Бүх давхарт байгаа агааржуулалтын хоолойг будах;
 - Ариун цэврийн зарим өрөөний угаалтуур суултуур тавигдаагүй байна;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ариун цэврийн өрөөнд бариул суулгах;
 - Хаалганы хүрээнд силикон хийх;
 - Өнгөрсөн зун подвальд их хэмжээний ус орсон;
 - Иймд ус зайлуулах усны хаялгыг өөрчлөх;
 - Зоорийн давхарт их хэмжээний ус алддаг;
 - Гадна үүдний дээд талд ус ус зайлуулах шугамыг хийх;
 - Лабораторын өрөөний шаланд цахилгааны разетка дутуу байгааг гүйцээх;
 - Гадна, гал тогооны өрөөний хойд хаалганы дээд талд ус хаялга хийх. Дээвэр хийх;
 - 4-р давхарт хаалганы хагарал засах;
 - Коридор, 3-р давхарт булангууд сэтэрсэн;
 - 3-р давхарт цонхны тавцан хагарсныг солих;
 - 2-р давхрын том цонхны /фасадны/ хүрээний будаг хуурсныг будах;
 - 2-р даврын булангийн өрөөг будах;
 - 2-р давхарт булангийн өрөөг будах;
 - Цууралттай өрөөнүүдийн будаг шинэчлэх;
 - 4-р давхарт коридорын ханын шавар унасан байна. Сэргээн засах;
 - Шатны хана дагасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний бариул тогтоох;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК, техник хяналтын инженер Б.Цэрэннадмид:

- Гадна цахилгааны дэд өртөөний комиссын дүгнэлт, залгах зөвшөөрөл шалгуулах;
- Гадна цахилгааны 0.4кВ-ийн ЦДКШ-ыг угсралтыг хийж ил далд ажлын актаар баталгаажуулан шалгуулах;
- Дизель генераторт давтан газардуулга хийх. Эсэргүүцэл хэмжүүлсэн протокол авах, хамгаалалтын хашаа хийх;

- Батлагдсан ажлын зургийн дагуу дизель генераторын холболт хийх, ашиглалтанд оруулж туршиж шалгах, ашиглалтын заавар боловсруулж ашиглагчид өгөх;
- Дизель генераторын 33Т-ийн ШҮХ-т бүртгүүлж, шуурхай ажиллагааны гэрээ хийх;
- ЕОС, ХС-уудад хаяг бичиглэл хийж схем байршуулах;
- Давхрын самбаруудад аюулгүй ажиллагааны анхааруулах плакат хадах;
- Аянгын торыг зэврэлтээс хамгаалж будах, дээврийн бүх металл хийцүүдийг торонд холбох;
- Аянга хүлээн авах антен хийх;
- Дутуу тоноглолуудыг гүйцээж угсрах;
- Аянга болон давтан газардуулгын эсэргүүцэл хэмжүүлсэн протокол шалгуулах;
- Үндсэн тэжээлийг холбож түр тэжээлийн самбар, кабелийг хурааж цэгцлэх;
- Давхрын самбаруудад "0"-ийн холболтуудыг тус бүрт нь төгсгөвч хийж холбох.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар
Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ**:

- Камерийн хяналтын бичлэгийг хамгийн багадаа 1 сар хадгалдаг байхаар хардны багтаамж нэмэгдүүлэх /одоо 24 хоног хадгалж байна/;
- Дотор холбоо дохиололын ил далд ажлын актуудыг бүрдүүлж, ашиглалч байгууллагаар давхар баталгаажуулах;
- Зоорийн давхрын болон давхрын самбаруудыг хаягжуулах;
- Сувилагчийг дуудах системийг бүрэн угсарч хэвийн ажиллагаанд оруулах;
- Дутуу суурилуулсан сүлжээний разетка гүйцээж суурилуулах /3 давхрын 303 тоот өрөө/.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Зүүн Түгээх Төвийн ахлах инженер
Б.Оргил:

- Холигч насосны узелийн болон салхивчийн узелийн тоног төхөөрөмж хаягжуулалт хийх;
- Салхивчийн узельд гарах агаарын термометр хэмжигч суурилуулах;
- Халаалтын дотор системийн халаах хэрэгсэлд термостат винтель суурилуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ**:

- №637/20 тоот техникийн нөхцлийн дагуу батлагдсан 2021.02.03 ажлын зургийн БУХ-2, 5-г шалгуулах, бохир усны шугамыг өргөтгөх гэж заасныг тодорхой болгож, албан бичгээр тайлбар ирүүлэх;
 - Цэвэр усны холболт авсан худгийн усны алдагдлыг зогсоож, хаалт арматурыг фото зургаар баримтжуулж шалгуулах /УУШ-огтолгоо ф50мм/;
 - Гадна цэвэр, бохир усны шугамын гүйцэтгэлийн зураг, мэдээллийн санд оруулсан акт шалгуулах;
 - БУХ-4 буюу бохир усны гаргалгааны худагт хөлдөлт үүссэн байгаа учраас зурагт тусгагдсан халаагч кабель угсарсан эсэх фото акт шалгуулах, тайлбар, баталгаа албан бичгээр ирүүлэх;
 - Гадна цэвэр, бохир усны шугамын ил далд ажлын актыг хангагч байгууллагаар баталгаажуулах;
 - Зоорийн давхрын бохир усны насосны ажиллагаа, холболтыг шалгуулах /видео/;
 - Нөөцийн савны угаалга, халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгүүлж акт үйлдэж шалгуулах;
 - Нөөцийн сав болон дотор ус авах хэрэгслээс ундны усны сорьц өгөж /НЭМГ-т хүсэлт / шинжилгээний дүн, байцаагчийн дүгнэлт шалгуулах;
 - Дотор сантехникийн хэрэгслүүдийг гүйцээж суурилуулах, тоноглол суултуурыг бэхлэх;
 - Нөөцийн савны өрөөнд ус зайлуулах трап приямок хийх;
 - Унд ахуйн усны насосны техникийн үзүүлэлт паспорт шалгуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын инженер **Г.Батбаяр**:

- Аянга хүлээн авагч суурилуулах;
- Ерөнхий самбар, давхрын самбаруудад аюулгүй ажиллагааны анхааруулах плакат байршуулах, зарчмын схем, автоматтуудыг хаягжилт хийх;
- Дээвэрт байрлах бүх металл хийцүүдийг хүрээ газардуулга, аянгын тортой холбох;
- Генераторын холболтыг хийж гүйцээх;
- Баримт бичгийг бүрдэл хангах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Б.Оюунжаргал**:

- Архивт баримтаа "Барилга байгууламж ашигалалтад оруулах дүрэм"-ийн 5-р хавсралтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх;
- Ил далд ажлын актыг буулгалтын ажлаас эхлэн барилга угсралтын ажлын дарааллаар эмхлэн нэгтгэж, акт тус бүрээр дотоод товъёг үйлдэж өгөх /өөрчлөлтийн зураг зоорийн давхарт хийгдвэл эх хувиар өгөх/
- Хувийн хэргийг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй /нэмэлт сунгалт бүгдийг хийх/ дотоод товъёг хийж өгөх;
- Ажлын зургийг зургийн бүрдлийн дагуу бүрэн бүрдэлтэй эх хувиар өгөх;

- Барилга угсралтын тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж, хаягжуулан эх хувиар өгөх;
 - Материалын сертификат, тохирлын гэрчилгээг дотоод товъёг үйлдэж өгөх.
- Үүрэг даалгавараар ашиглатанд оруулах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа **Ч.Артаг:**

- Зоорийн давхарт одоо байгаа өөрчлөлтийн дагуу гүйцэтгэлийн зураг гаргах;
- Зоорийн давхарт зургийн дагуу галын дохиололыг бүрэн хийж, хоолой шугамын цаагуур далд орсон системийг гаргах;
- ОБЕГ-с зураг хянасан дүгнэлтийг нөхөж үзүүлэх;
- Галын дотуур усны даралтыг хэмжих;
- Гадна дулаалгын материал шинжилгээнд оруулсан бичиг нөхөж үзүүлэх;
- Давхруудын галын дотор усны даралтат цэгийг холбох тотгыг гал унтраах багаж зэвсэглэлтэй холбож болохоор болгох /Богданов төрлийн болгон засах/;
- Ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна орчны тохижилтыг бүрэн хийж дуусгах;
- Үүрэг даалгаврын биелэлтийг албан бичиг болон фото зургаар өгөх;
- Дохиололын сигналын чадлыг нэмэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Нийтийн авто зогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын 2м45см машин зогсож 1м 50см тэргэнцэртэй бууж суухад зориулж эрээн шугам татаж тусгаарлаж өгнө. Зогсоолын урд 1м 80см шон 60*60 см самбар хийнэ;
- Явган замд хөтөч зам хийнэ;
- Явган замын налууг 6 градусуас ихгүй болгох;
- Хүлээн авалтын хаалганы налууг стандартын болгох, 1 талд нэмж бариул хийх;
- Төв хаалганы налуу замын баруун талд 20см өндөр 10см өргөнтэй хашилт хийнэ;
- 4-р давхрын ХБХ ариун цэврийн өрөөний суултуур, угаалтуурыг MNS6055 стандартын шаардлага хангасан туслах тоноглол суурилуулах;
- Цахилгаан шатанд хаалганы үйлдэл, давхар зарлах, зарлан мэдээлэх төхөөрөмжийг суурилуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөр төлөх;
- Зоорийн давхрын өрөөнүүдийн шал өнгөлөх;
- Дотор засал, хялгасан хагарал, гадна фасадны чигжээс, цонхны чулуун тавцангийн силиконы ажил зэргийг дахин хийх;
- Техникийн давхарт дээвэр рүү гарах шат стандартын дагуу хийх;
- Дээврийн ашиглалтын хэвийн нөхцлийг хангуулж хог хаягдал цэвэрлэх;
- Гадна тохижилт, ногоон байгууламжийг дулааны улиралд гүйцээх баталгаа албан бичиг ирүүлэх;
- Хагарсан цонх, шил солих;
- Хөрсний уснаас хамгаалахаар авсан арга хэмжээний акт, хүйтний улиралд ажил гүйцэтгэх технологийн карт, бетоны шинжилгээ зэргийг нөхөж шалгуулах;
- Явцын хяналт хийсэн захиалагч, зохиогчоос өгсөн үүрэг даалгаврыг улаан дэвтэрт нөхөж бичих;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Эрүүл Мэндийн Яам, Санхүү эдийн засгийн бодлогын газрын хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн **Б.Нямсүрэн:**

- Дотор заслын ремонт хийх;
- Рентгений өрөөний зохион байгуулалт өөрчлөх;
- ТБОНӨБААХАХ-н хүрээнд барьцаа 5% ЭМЯ-ны барьцаа баталгааны дансанд байршуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Зураг төслийн Шувууны Хайрга ХХК-ийн захирал **В.Ганбаатар:**

- Цахилгааны самбарын хаягжилтыг хийж өгөх;
- Давхрын болон гэрэлтүүлгийн самбарын схемийг байрлуулах;
- Ашиглалтанд орсны дараа ашиглагчид гүйцэтгэгч тоног төхөөрөмжийн гарын авлага бэлтгэж өгөх;
- Ашиглагч тал дизель генераторыг ашиглалтын үед тоног төхөөрөмжийн гэрээ байгуулна;
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг нэгтгэж зохиогчид өгөх;
- Хариуцсан зураг төслийн инженерүүдийг хувиарлаж биелэлтийг хамтран зөвлөлдөж биелэлтүүдийг комиссын гишүүдэд баталгаажуулах;
- Зохиогчийн дүгнэлтийг дахин шинээр авах;
- Бичиг баримтын холбогдох хувийг ашиглагч, Архивын ерөнхий газар, зохиогчид хүргүүлэх болно;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Гүйцэтгэгч Хаппи Бьюлдинг ХХК-ийн захирал **Б.Отгонбаатар:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**:

- МУ-ын ЗГ-ын 212 тогтоолын хавсралт Барилга ашиглалтад оруулах дүрмийн 8.1-т заасан хугацаанд гадна цахилгаан хангамжийг ашиглалтанд оруулж, дүгнэлт баталгаажуулах;
- Барилгын гүйцэтгэгч, зураг төсөл зохиогчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг ирүүлэх;
- Дутуу хийгдсэн ногоон байгууламж тохижилтын ажлыг гүйцэтгэх хугацаа заасан баталгаа албан бичгээр ирүүлэх;
- Барилга байгууламжийн батлагдсан төсөв, зураг төслийн дагуу ашиглагчтай актаар хүлээлцсэн хувийг ирүүлэх;
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгааг гаргаж албан бичгээр ирүүлэх.


Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 8 давхар, 1 блок, 24.0м*15.0м, 160 (нэг зуун жаран) ор бүхий хүчин чадалтай ахмад настан, хүүхдийн эмнэлгийн зориулалттай барилгыг ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын
Барилга байгууламжийн захиалагчийн
хяналтын хэлтсийн Хяналтын инженер

(Г.Батбаяр)